

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03-р сарын 11 өдөр

Дугаар 05/2022

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлөх,
гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон
гүйцэтгэгчийг томилох тухай

“Хархорин” ХК-ийн гүйцэтгэх захирал Р.Саранцэцэгийн гаргасан хүсэлтийг үндэслэн
Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Хархорин” ХК-ийн гүйцэтгэх захирал Р.Саранцэцэгийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлж бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Хархорин” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд тохирох этгээдийг нэр дэвшүүлж батлах, Санхүүгийн зохицуулах хорооноос шинээр томилогдох гүйцэтгэх захирлыг зөвшөөрч улсын бүртгэлд бүртгүүлэх хүртэл хугацаанд “Хархорин” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ТУЗ-ийн ердийн гишүүн Пүрэвийн Учралыг томилсугай.
3. Р.Саранцэцэгтэй холбоотой тооцоог хийж өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахыг Ерөнхий нягтлан бодогч Д.Дашмаад даалгасугай
4. Компанийн харилцах данснуудын нэгдүгээр гарын үсэг зурах албан тушаалтнаас Р.Саранцэцэгийг хасаж, гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон П.Учралыг томилсугай.
5. Компанийн харилцах данснуудын нэгдүгээр гарын үсэг зурах албан тушаалтны өөрчлөлтийг “Хархорин” ХК-ийн харилцдаг банк, санхүүгийн байгууллагуудад бүртгүүлэхийг ерөнхий нягтлан бодогч Д.Дашмаад даалгасугай.
6. Компанийн гүйцэтгэх удирдлагад орж байгаа өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ганбатад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.БИШРЭЛ